

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ БОДЛОГО

"Стор Пэй ББСБ" ХХК-ийн Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны бодлого нь дэвшилтэт технологиор дамжуулан үзүүлж буй санхүүгийн үйлчилгээ, хэрэглэгч, хамтран ажиллаж буй байгууллагын мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжтэй байдлыг хангах зорилгоор ISO/IEC 27001:2022 стандартын дагуу Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоог бий болгох, хэрэгжүүлэх, хянах, тасралтгүй сайжруулахыг зорино.

Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцоо нь дараах бодлогыг баримтална:

1. Нууцлал: Мэдээллийн нууцлалыг хангахдаа "Нууцлалын бодлого"-д тодорхойлсны дагуу хэрэгжүүлнэ.
2. Хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлага: Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Монгол улсын хууль, зохицуулагч байгууллагын мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой дүрэм, журам, стандартын шаардлагын нийцлийг хангана. Үүнд:
 - Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль
 - Кибер аюулгүй байдлын тухай хууль
 - Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
 - Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль
 - Цахим гарын үсгийн тухай хууль
 - Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль
3. Бизнесийн тасралтгүй үйл ажиллагаа: Компанийн хэрэглэгч, хамтран ажиллаж буй байгууллагын мэдээллийн аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлж бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг хангахыг зорих бөгөөд шаардлагатай технологи, хүний нөөц болон санхүүгийн нөөцөөр тогтмол хангана.
4. Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн удирдлага: Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, түүнийг зөв зохистой удирдах бүхий л харилцааг ISO/IEC 27001:2022 стандартад нийцүүлэн хэрэгжүүлнэ.
5. Хяналт үнэлгээ сайжруулалт: Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны хэрэгжилт, үр дүнг жилд хамгийн багадаа нэг удаа тооцож сайжруулалт хийдэг байна.
6. Мэдээллийн хамгаалалт: Мэдээллийн аюулгүй байдлын шаардлагыг тогтмол хангаж, шаардлагатай технологи, санхүүгийн нөөц, хүний нөөц, шинэлэг технологийг ашиглан байгууллагын мэдээллийг алдагдахаас сэргийлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэн хэрэглэгч, мерчант, харилцагч байгууллагуудын мэдээллийг хамгаалахад оршино.
7. Ажилтны мэдлэг, чадавх: Нийт ажилтнуудын мэдээллийн аюулгүй байдлын мэдлэгийг дээшлүүлж, мэдээллийн аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулж, аюулгүй ажиллагааны соёлыг байгууллагын хэмжээнд төлөвшүүлнэ.

"СТОП ПЭЙ ББСБ" ХХК